



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 262

Улаанбаатар хот

Үнэт цаасны зах зээлд оролцогчдоос төвлөрүүлэх
зохицуулалтын үйлчилгээний хөлсийг шинэчлэн тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ”Үнэт цаасны зах зээлд оролцогчдоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 156 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг шинэчлэн тогтоох тухай журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дор дурьдсан хуваарийн дагуу төвлөрүүлж байхаар тогтсугай:

1/Үнэт цаасны арилжааны гүйлгээнээс олсон шимтгэлийн орлогоос Хороонд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг арилжаа явагдсан өдөр бүр тооцож, үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь Хорооны дансанд;

2/Жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тухайн оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор Төрийн сан банк дахь Хорооны 900025001 тоот дансанд;

3/Үйлчилгээ үзүүлсэн тухай бүр нэг удаа авах зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тухай бүр Төрийн сан банк дахь Хорооны 900025001 тоот дансанд.

4. Энэхүү тогтоолтой нийцүүлэн холбогдох дүрэм, журам, төлбөр тооцооны програмд оруулбал зохих өөрчлөлтийг ажлын 5 хоногт багтаан оруулж Хороонд ирүүлэх, 2014 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдөхийг үнэт цаасны зах зээлийн оролцогч этгээдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

/төгрөгөөр/

№	ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛЧИЛГЭЭ		ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС		
	ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, ЭРХ, ҮЙЛЧИЛГЭЭ	БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГИЙН ХУВЬ	ЖИЛИЙН ДҮН	ТУХАЙ БҮР ДҮН
1	<p>1.1 Арилжаа эрхлэх 1.2 Төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, өмчлөх эрх бүртгэл /биржийн арилжааны / 1.3 Брокер 1.4 Дилер <i>/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i></p>	<p>1. а/ Хувьцаа 1. б/ Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын бонд 1. в/ Компанийн өрийн хэрэгсэл <i>/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i></p>	<p>1.1-1.2 Үнэт цаасны биржийн арилжааны хэлцлийн үнийн дүнгээс зохицуулалттай этгээдийн шимтгэлийн орлогын 10 хувь 1.3-1.4 а/ Хувьцааны арилжааны худалдах, худалдан авах хэлцэл тус бүрийн үнийн дүнгийн 0,04 хувь; 1.3-1.4 б/ Хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны хэлцлээс олсон шимтгэлийн орлогын 10 хувь <i>/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор өөрчлөлт</i></p>	- - -	- - -

¹ Үнэт цаасны төлбөр тооцоо эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс авах зохицуулалт үйлчилгээний хөлсний нийт хэмжээ нь биржийн арилжаа болон биржийн бус арилжааны гүйлгээний нийлбэрээр тодорхойлогдоно.

			<i>оруулсан/</i>		
2	<p>Төлбөр тооцоо /биржийн бус/</p> <p><i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i></p>	<p>2.1.1. өөрийн эхнэр, эсхүл нөхөр, өөрийн болон эхнэр, эсхүл нөхрийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, авга, нагац, ах, эгч, дүү, төрүүлсэн болон үрчилж эсхүл нөхрийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, авга, нагац, ах, эгч, дүү, төрүүлсэн болон үрчилж авсан хүүхэд, ач зээ, тэдгээрийн хүүхэд зэрэг төрөл, садангийн хүнээс гадна, хүргэн бэрд үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бэлэглэсэн гүйлгээг гүйцэтгэх үйлчилгээ</p> <p><i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор шинэчлэн найруулсан/</i></p>	<p>2.1.1. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 20 хувь</p> <p><i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор шинэчлэн найруулсан/</i></p>	-	-
		<p>2.1.2. Энэхүү хавсралтын 2.1.1-д зааснаас бусад иргэн, хуулийн этгээдийн хооронд хийгдсэн үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бэлэглэхтэй холбоотой гүйлгээг гүйцэтгэх үйлчилгээ</p> <p><i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i></p>	<p>2.1.2. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 20 хувь</p> <p><i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i></p>	-	-

		<p>2.2. Өвлүүлэх гүйлгээг гүйцэтгэх үйлчилгээ <i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i></p>	<p>2.2. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 20 хувь <i>Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i></p>	-	-
		<p>2.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх үйлчилгээ <i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i></p>	<p>2.3. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 20 хувь <i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i></p>		
		<p>2.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлээс бусад журмаар үүргийн гүйцэтгэл хангах <i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i></p>	<p>2.4. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 20 хувь <i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i></p>	-	-
		<p>2.5. Засгийн газрын бонд <i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i></p>	<p>2.5. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 20 хувь <i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i></p>	-	-

		2.6. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас <i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i>	2.6. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 20 хувь <i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i>	-	-
		2.7. Бусад гүйлгээ <i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i>	2.7. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 10 хувь <i>/Энэ хэсэгт Санхүүгийн захицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 275 дугаар тогтоолоор нэмсэн/</i>	-	-
3	3.1 Андеррайтер	3.1.1 Андеррайтерын үйлчилгээ	-	2 000 000	-
4	4.1 Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх	4.1.1 Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа	-	1 000 000	-
5	5.1 Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх	-	-	1 000 000	-
6	6.1 Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэл	-	-		1 000 000
7	7.1 Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил	7.1.1 Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын ажил	-	500 000	-

	үйлчилгээ	үйлчилгээ эрхлэх			
8	8.1 Үнэт цаас итгэмжлэн удирдах	8.1.1 Үнэт цаас итгэмжлэн удирдах үйл ажиллагаа		500 000	-
9	9.1 Хөрөнгө оруулалтын зөвлөх	9.1.1 Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа	-	300 000	-
10	10.1 Кастодиан	10.1.1 Кастодианы үйл ажиллагаа		1 000 000	500 000
11	11.1 Өөрийгөө зохицуулах байгууллага	11.1.1 Өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэх, сэргээх	-	200 000	-
12	12.1 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад тусгагдсан зөвшөөрөл	12.1.1 Салбарын зөвшөөрөл олгох /Улаанбаатар, Эрдэнэт, Дархан/ Орон нутаг	-	-	100 000
				-	20 000
		12.1.2 Оноосон нэр өөрчлөх	-	-	2 000 000
		12.1.3 Тусгай зөвшөөрлийг сэргээх	-	-	500 000
		12.1.4 Гүйцэтгэх захирлыг томилохыг зөвшөөрөх	-	-	50 000
		12.1.5 Хувь нийлүүлэгчдийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт оруулах	-	-	100 000
	12.1.6 Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах,	-	500 000	-	

		худалдан авахад зуучлах зөвшөөрөл			
		12.1.7 Харилцагчийн нэгдсэн /номинал/ данс эзэмших зөвшөөрөл	-	500 000	-
13	13.1 Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах /Компани өөрчлөн байгуулах/ ХХК болон хэлбэрээ өөрчлөх, нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах болон үнэт цаас нэмж гаргах, хувьцаа хуваах, нэгтгэх/	-	-	-	200 000
14	14.1 Шинээр үнэт цаас бүртгүүлэх			-	500 000
15	15.1 Монгол Улсын хуулийн этгээдээс гадаад улсын зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх	-	-	-	500 000
16	16.1 Үнэт цаас гаргагчийн оноосон нэрийг өөрчлөх	-	-		2 000 000
17	17.1 Үнэт цаасыг бүртгэлээс хасах	-	-		200 000
18	18.1 Зэрэглэл тогтоох үйл ажиллагааг бүртгэх,	-	-	1 000 000	-

	зэрэглэл тогтоох эрх олгох				
19	19.1 Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа	-	-	1 000 000	-
20	20.1 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа	-	-	1 000 000	-
21	21.1 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа	-	-	1 000 000	-
22	22.1 Хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх	-	-	500 000	-
23	23.1 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх	-	-	1 000 000	-
24	24.1 Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх	-	-	100 000	-
25	25.1 Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх	-	-	100 000	-
26	26.1 Үнэт цаасны зах зээлд	-	-	100 000	-

	оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх				
27	27.1 Баримт бичиг хуулбарлан өгөх	-	-	-	1'000 /нүүр тус бүрээс/